



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/154

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2019 оны “Түрээсийн орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай” 223 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын XIV хуралдааны 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн “Орон сууцны талаар авах зарим арга хэмжээний тухай” 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлсэн Шинэ мөрөн хорооллын 135 айлын орон сууцны барилгыг худалдах, худалдан авах талаар аймгийн Засаг дарга, Хөгжлийн банк хооронд 2021 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан гэрээний хууль эрх зүйн үндэслэлийг судлан тогтоох, тус орон сууцыг түрээсэлсэн иргэдтэй аймгийн Засаг дарга уулзалт хийх ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнгөн-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
Гишүүдэд: М.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)  
Б.Должинсорогдог (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)  
Б.Болд (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга)  
Б.Билэгт-Отгон (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны Бодлого төлөвлөлт, хууль эрх зүйн албаны дарга)  
Нарийн бичгийн дарга: Д.Далайжаргал (Орон сууцны ашиглалт, төлбөр тооцоо хариуцсан ажилтан)

2. Аймгийн Засаг дарга, Хөгжлийн банк хооронд 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан орон сууц худалдах, худалдан авах тухай гэрээний хууль эрх зүйн үндэслэлийг судалж, гэрээний нөхцөл, төлбөрийн хуваарийг судлан, гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах эсэх талаар баримт бичгийн төсөл боловсруулах, орон сууц түрээслэгч иргэдтэй болон Монгол Улсын Хөгжлийн банкны удирдлагын төлөөлөлтэй уулзах аймгийн Засаг даргын уулзалтыг зохион байгуулж тайлагнахыг тус тус ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

d/zahiramj

671 010577